

7

ГОВЬ ХК-НЫ ӨРТГИЙН ШИНЭЧЛЭЛ: ТУРШИЛТ, ҮР ДҮН**Т.Жааваа**

Үйлдвэр худалдааны "Говь" ХК нь 1981 онд байгуулагдсан, эх орны ноолуурын хөнгөн аж үйлдвэрийн гол төлөөлөгч, үнэ цэнэтэй үндэсний үйлдвэр билээ. Нягтлан бодох бүртгэл шинэчлэл 90-ээд оны дундуур эхлэж, орчин үеийн өндөр хурдтай персонал компьютер нэвтэрч, мэдээллийн автоматжуулсан сүлжээ тавигдсан.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр "Артур Андерсон" компаниас гадаад санхүүгийн тайлангийн загварыг олон улсын бүртгэлийн стандартын дагуу өөрчлөх анхны туршилтууд хийгдэж, 8 оронт дансны ангилал, код, нэгдсэн жагсаалт анх нэвтэрснийг эдүгээ хүртэл сайжруулан хэрэглэж, санхүүгийн мэдээлэл боловсруулалтад DOS орчны "Платинум", Windows-95, 98, Office-97, 2000 хамгийн сүүлийн үеийн хэрэглээний программ сонгож хэрэглэх болов.

Энэ бүхний дүнд тус үйлдвэрийн төсөвлөлт, дотоод бүртгэл хяналт, гадаад санхүүгийн тайлагналд мэдэгдэхүйц дэвшил гарсаар байна. 20 жилийн түүхэн замналтай тус үйлдвэрт нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан, мэдээлэл боловсруулалтад багагүй туршлага хуримтлагдаж, үйл ажиллагааны дотоод төсөвлөлт, хяналт, тайлагналын өвөрмөц тогтолцоо нэгэнт бүрджээ. Гэвч дараах эрэлт, шаардлагыг иш үндэс болгож санхүүгийн мэдээллийн цар хүрээг сайжруулах төслийн хүрээнд хамтран ажиллахыг бидэнд санал болгосон.

Нэг, Санхүүгийн мэдээлэл, дотоод төсөвлөлт, хяналт, тайлагнал дахь хамтын туршлагыг нэгтгэж, ажлын ололт, үнэт зүйл, нэгэнт хүрсэн төвшинг баталгаажуулахын хамт мэдээллийн шинэчлэл, олон улсын бүртгэлийн стандарт, монгол улсын татварын багц хууль, бусад хуулийн шаардлагад нийцүүлэн бүртгэлийн бодлого горимыг эргэн хянаж, санхүүгийн шинэчилсэн бүртгэлийн загвар, заавар журам бэлтгэх.

Хоёр, Өнөөдөр "Говь" ХК-нд 2 үйлдвэр, дараалсан, зэрэгцээ 35 дамжлага, бүтээгдэхүүн хувиргалтын 27 цех тасгаас гадна агааржуулалт, туршилт, засвар үйлчилгээ, цахилгаан,

сантехник, механик цех зэрэг туслан үйлчлэх салбар, бас амралт, сувилал, гуанз, орон сууц, цэцэрлэг, зоорь зэрэг үйлдвэрлэлийн бус хүрээний томоохон дэд бүтэц бүхий цогцолборууд харьяалагддаг. Энэ цогцолбор, хилийн чанад, хөдөө орон нутгийн салбар нэгжүүд өөр өөр нутаг дэвсгэр, газар зүйн байрлалтай ч одоо хир бие даасан санхүүгийн тайлан гаргадаггүй, тэр ч бүү хэл дотоод эргэлт, материаллаг солилцоо ихтэй ч дотоод үнэ, шилжилт зэрэг төв ба салбарын зохион байгуулалт бүхий бизнес хамсралын энгийн бүртгэл, тайлагналын элементүүд нэвтрээгүй байв.

“Говь” ХК хувьчлалд бэлтгэхдээ гадаад санхүүгийн тайлагнал дахь төвлөрлийг саармагжуулж, нягтлан бодох бүртгэлийн төвлөрсөн зохион байгуулалт, бүтцийг эргэж хянах, төв болон салбарын зохион байгуулалт бүхий бизнес хамсралын хамгийн энгийн хэлбэрээр салбар нэгжүүдийн санхүүгийн бие даасан тайлангуудыг нэгтгэж, гадаад санхүүгийн нэгдсэн тайлан бэлтгэх чиглэлээр өөрчлөх шаардлага ч өнөөдөр буйг үгүйсгэх аргагүй билээ.

Гурав, Шинэчлэлд зөвхөн гадаад бүртгэл тайлагнал өртөж, дотоод мэдээллийн сүлжээ, ялангуяа цех тасаг, дамжлагын өртгийн хяналт, нэгтгэл, калькуляци, борлуулалт, удирдлага, үйлдвэрлэлийн бус хүрээний төсөвлөлт, хяналт, тайлагналын систем өнөөдрийг хүртэл тогтсон нэг загварт орж журамлагдаагүй, хуучнаар явж ирсэн. Эндээс технологи горим, бүтээгдэхүүн хувиргалт, үйлдвэрлэлийн бүх цех тасаг, дамжлага, үндсэн, туслан үйлчлэх сегмент, тэрчлэн үйлвэрлэлийн бус хүрээг хамруулан өртөг хяналтын системийг бүхэлд нь эргэж хянах явдал зайлшгүй болжээ.

Тэгээд ч бид үйлдвэрлэлийн бүх салбар, нэгжүүдийн анхан шатны бүртгэл хөтлөлт, өртгийн хяналтын бүдүүвчийг эргэн хянаж, өнгөрсөн 20 жилийн туршлага, ололт, үнэт зүйлийг баталгаажуулахын хамт санхүүгийн мэдээллийн шинэтгэлд нийцүүлэн хэд хэдэн заавар журам эцэслэн бэлтгэж, хэлэлцүүлсэн ба өнөөдөр туршин нэвтрүүлсэн болно. Үүнд:

Нэгд, үйлдвэрлэлийн 19 цех тасаг, дамжлагад “Үндсэн цех тасгийн анхан шатны бүртгэлийн альбом” (13 хэсэг, 200 орчим хуудастай). Өмнөх заавар, альбомыг хянаж сайжруулсны дээр говь-2 үйлдвэрийн 7 дамжлагад хэрэглэх анхан шатны бүртгэл хөтлөлтийн альбом шинээр бэлтгэсэн.

Хоёрт, Технологи, бүтээгдэхүүн хувиргалтын 35 дамжлага, 27 цех, тасаг, нэгж дээр “Цех тасгийн анхан шатны бүртгэл хөтлөлт, өртөг тооцолтын заавар” (19 хэсэг, 500 хуудас материал). Оролцогч талууд санал өгч, цех, тасаг, нэгжүүд 2000 оноос туршин, 2001 онд үйлдвэрлэлд шилжүүлсэн.

Гуравт, “Дуусаагүй үйлдвэрлэлийн нэгтгэл, өртгийн калькуляци, тайлан, борлуулалт, удирдлагын зардал, үйлдвэрлэлийн бус хүрээ: орлого, зардал, үр дүнгийн төсөвлөлт, хяналт, тайлагналын шинэчилсэн загвар” (5 хэсэг, 100 хуудас). Холбогдох хүмүүс санал өгч, 2001 онд үйлдвэрлэлд нэвтэрсэн.

Санхүүгийн мэдээллийн цар хүрээ, шинэчлэл төслийн хүрээнд хийгдсэн дээрх алхмын үр дүнд мэдээллийн дотоод сүлжээ, өртгийн хяналтын хэв загварт үндсэн эргэлт дэвшил гарч, хамт олны хичээл зүтгэл, хөдөлмөрийн үр шим жинхэнэ ёсоор баталгаажих эх суурь тавигдсан гэж болно. Бидний бодлоор төслийг цаашид үргэлжлүүлэх дараах бодит шалтгаан байгаа юм. Үүнд:

- Өмч, хөрөнгө, үүрэг хариуцлага, санхүүгийн элементүүд, тухайлбал мөнгөн хөрөнгө, авлага, өглөг, биет, биет бус хөрөнгө, эздийн өмч, гадаад санхүүгийн тайлангийн өнөөгийн бүдүүвчийг эргэн хянаж, хуримтлагдсан туршлагыг нэгтгэх ба гадаад, дотоод мэдээллийн сүлжээг бүхэлд нь хамарсан нягтлан бодох бүртгэлийн нэгдмэл бодлого горим хэвшүүлэх
- Удирдлагын төвлөрлийг саармагжуулж, төв ба салбар бүхий бизнес хамсрал үүсгэх, улмаар нягтлан бодох бүртгэлийн төвлөрсөн зохион байгуулалтыг задлаж, салбар нэгжийн бие даалт, дотоод үнэ, шилжилт, сегмент, хариуцлагын тайлагналын элементүүдийг нэвтрүүлэх

Санхүү, өртөг, удирдлагын бүртгэл, дотоод хяналт, мэдээллийн сүлжээний дээрх шинэчилсэн загваруудыг windows орчны хамгийн сүүлийн хэрэглээний программд хөрвүүлж, салбар нэгжүүдэд мэдээллийн автоматжуулсан сүлжээ тавих, сүлжээний давуу талыг төгс ашиглах зэрэг болно. Өнөөдөр “LAS Visual Advance - 2000” Америк санхүү бүртгэлийн хамгийн сүүлийн хэрэглээний программ худалдан авч, суурилуулж буй нь ч үүнтэй холбоотой.

Анхан шатны бүртгэл, өртгийн ваучер

Альбом. Технологи хувиргалтын 35 дамжлага, үйлдвэрлэлийн 19 цех, тасаг, салбар, нэгж хамарсан анхан шатны бүртгэлийн альбом бол хамт олны 20 жилийн хичээл зүтгэл, түүхэн туршлагыг нэгтгэсний үр дүн бөгөөд анхан шатны нэгжийн удирдлага, цехийн мастер, технологич инженер, тооцоо гаргагч, эд хариуцагч, ажилчид, цехийн нягтлан бодогч зэрэг олон хүний хичээл зүтгэл, хамтын хүчин чармайлтын үр дүнд бэлтгэгдсэн болохыг энд зориуд дурдах хэрэгтэй.

Талуудтай зөвшиж, санал солилцсоны эцэст ноос, ноолуурын технологи, бүтээгдэхүүн хувиргалт, өртөг хяналтын шинэчилсэн загварт нийцүүлэн 105 нэрийн маягт хэрэглэхээр сонгож, зохих сайжруулалт хийсний дээр үндсэн цех, тасаг, дамжлагуудад давхардсан тоогоор 325 нэрийн маягт мөрдүүлж хэвшүүлэхээр альбомд тусгаж, зохих заавар, аргачилсан зөвлөмжүүдийг бэлтгэсэн.

Өртгийн ваучер. “Говь” ХК санхүүгийн мэдээлэл шинэчлэлийн чухал үр дүн бол сегмент өртгийн бүрдэл, хяналтад илүү зохицсон ерөнхий дансны нилээд дэвшилт зохиомж - журнал ваучер систем хэрэглэж хэвшсэн явдал юм. Журнал ваучерын хяналтад өнөөдөр технологи хувиргалтын 35 дамжлага, түүний дотор Ангилан ялгах, Склад, Хялгас ялгах, Будах, Ээрэх, Утасны склад, Монкашмер, Загвар, Захиалгат, Сүлжих, Оёх, Гүйцэтгэх, Нэхэх, Зөөлөн оёдол зэрэг үйлдвэрлэлийн 27 цех, тасаг, сегмент хамрагдаад байгаа юм.

Цех, тасгийн сегмент өртөг сар бүр эх баримт бүрдлээр “Өртгийн нэгтгэл” (Ж-5) ваучерт дэлгэрэнгүй зүйлчлэгдэхээс гадна “Дуусаагүй үйлдвэрлэл” дансдын гүйлгээг нэгдсэн ангилал кодын дагуу түүвэрлэж, нэгтгэхийн тулд “Дансны товчоо” (Ж-6) туслах ваучер ашиглана. Өртгийн ваучерууд дотроо “Түүхий эд” (Ж-1), “Хими материал” (Ж-2), “Туслах материал” (Ж-3), “Дамжлагын журнал” (Ж-4), “Нэгтгэл” (Ж-5), “Товчоо” (Ж-6) гэсэн иж бүрдэлтэй байх авч, үе шатны өртөг хяналтад бүх цех, тасаг, салбар, нэгжүүд “Өртгийн нэгтгэл” (Ж-5), “Дансны товчоо” (Ж-6) ваучеруудыг зайлшгүй нээж, түгээмэл хэрэглэж хэвшүүлэхээр энэ зааварт тунхагласан.

“Өртгийн нэгтгэл” (Ж-5) ваучерт дамжлагын өртөг 25 нэрийн дэлгэрэнгүй зүйл, задгай жагсаалтаар зүйлчлэхээр заасан нь хяналтын ач холбогдолтой зүйл билээ. Бас дамжлагаар оруулсан, боловсруулсан, шилжүүлсэн, үлдэгдэл зүйлсийн жинлэсэн дундаж өртгийг дуудах, тэдгээрийн тоо, метр, жингийн баланс хийгээд нэгж дундаж өртөг, нийт өртгийн дэлгэрэнгүй жагсаалт тодорхойлолт зайлшгүй хавсаргах, тэрчлэн сар бүр бүх цех, тасаг, нэгжүүд “Өртгийн нэгтгэл” (Ж-5) ваучерт зүйлчилсэн өртгийн дүнгээс дотоод эргэлт буюу цех тасаг, дамжлага, сегмент хоорондын материал, түүхий эд, хагас боловсруулсан эдлэхүүн, бусад зүйлсийн солилцоог хасаж, сегмент өртгийг дотоод эргэлтгүй цуглуулж, тайлагнах гэсэн түгээмэл нөхцлүүд энд тусгагдав.

“Дуусаагүй үйлдвэрлэл” дансдын журнал ваучер нэгтгэлд нийт зардлыг 29 нэрийн дэлгэрэнгүй зүйлчлэл, задгай жагсаалтаар тусгаж, шууд материал, шууд хөдөлмөр, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал гэсэн 3 дансны сувгаар давхар журамлаж, нэгтгэн товчоолно.

“Шууд материал” сувгаар түүхий эд склад, гаднаас оруулсан, тооллогын илүүдэл, Говь/

Пүүсээс авсан, өмнөх дамжлагаас оруулсан гэж түүхий эд, хагас боловсруулсан зүйлсийн хөдөлгөөнийг дэлгэрэнгүй тайлагнах нөхцлийг зааварт тусгав. Харин ангилсан ноос ноолуурын склад, говь/пүүсийн дотоод шилжилт болон өмнөх дамжлагаас оруулсан зүйлсийн жинлэсэн дундаж өртөг дотоод эргэлт учраас ваучер нэгтгэлд зардлын дүнгээс хасагдана. Дамжлагын ажилчдын хийснээрх свед, цаг зэргийн цалинг "Шууд хөдөлмөр" гэж үзнэ.

"Нэмэгдэл зардал" суваг 22 зүйл дэлгэрэнгүй жагсаалтаас бүрдэж, тэднийг шууд бус материал, шууд бус хөдөлмөр, үндсэн хөрөнгийн элэгдэл, урсгал засвар, ашиглалт, бусад зардал гэсэн дэд бүлгүүдээр давхар журамлах нөхцөл зааварт тусгагдсан. Энд туслах ба хими материал "шууд бус материал", тогтмол, нэмэгдэл цалин, ажил олгогчын хариуцах НДШ, ЭМД "Шууд бус хөдөлмөр", сэлбэг, засвар, техник үйлчилгээ "Урсгал засвар", цахилгаан, халаалт, уур хий, цэвэр бохир ус, салхивч агааржуулалт, холбоо "Ашиглалт", бичиг хэрэг, аж ахуй, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, газар хог, үйлчилгээний төлбөр, тээвэр шатахуун зэргийг "Бусад" дэд бүлгүүдэд журамлах хэрэгтэй гэж үзэв.

Говь ХК, пүүсийн дотоод эргэлтгүй сегмент өртгүүд жилийн эхнээс өссөн дүнгээр нэгтгэлд орж, өмнөх дамжлагаас авсан, хувиргаж шилжүүлсэн, үлдэгдэл зүйлсийн өртгүүд жинлэсэн дундажаар дуудагдах учир үлдэгдлийн тэнцэл дэх дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн үйлдэхүүн, бараа материалын үнэлгээ төгсжиж, гадаад санхүүгийн тайлагналд орлого үр дүн зөв илэрхийлэгдэх нөхцөл бүрдэнэ.

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийн тайлан. Санхүү, өртөг, удирдлагын хяналтын загварт чухал ач холбогдолтой, үндсэн цех, тасгийн сегмент өртгийн бүрдэл хийгээд дуусаагүй үйлдвэрлэл нэгтгэлд хяналтын чиг үүрэгтэй дотоод хяналтын гол тайлан. Уг тайланд түүхий эд, хагас боловсруулсан зүйл, эцсийн үйлдэхүүний хөдөлгөөний баланс нягт уялдаж хангагдсанаар дуусаагүй үйлдвэрлэлийн нэгтгэл зөв хийгдсэн, бас орлого үр дүнгийн тайланд шилжүүлсэн борлуулсан бүтээгдэхүүний өртөг үндсэн дансдын бичилтээр зөв тусгагдсан гэдгийг итгэл үнэмшилтэй нотлож өгдөг юм.

Дотоод хяналтын энэ мэдээ сүлжээний ач холбогдол: нэгд, дуусаагүй үйлдвэрлэлийн нэгтгэлд түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн, борлуулсан бүтээгдэхүүний өртгийн биет масс (тоо, жин), өртгийг баланслуулах, **хоёрт**, өртөг, үнийн калькуляцийн суурь дэвсгэр, **гуравт**, өртгийн гүйцэтгэл мэдээлэх, тайлагнах хэлбэр, бизнес хэл, **дөрөвт**, сегмент хооронд өртөг шилжүүлж, хорогдуулах бичилт хийх, дуусаагүй үйлдвэрлэл, бараа материалын нөөцийн үнэлгээ төгс хийгдсэн гэдгийг нотлох, **тавд**, гадаад санхүү, дотоод (зардал удирдлагын) мэдээллийн уялдааг хангах зэрэг үйлчилгээтэй болно. Бүтэц, зохиомж 4 хэсэгтэй. 1-р хэсэгт түүхий эд (материал), 2-р хэсэгт дуусаагүй үйлдвэрлэл, 3-р хэсэгт бэлэн үйлдэхүүн, 4-р хэсэгт борлуулсан бүтээгдэхүүний өртөг дансдын балансжилт, өгөгдлүүд тусгагдана.

Сегмент өртөг: шинэчилсэн бүдүүвч загвар

Технологи хувиргалтын 35 дамжлага, 27 цех тасаг, сегментийг хамарсан "Цех тасгийн анхан шатны бүртгэл хөтлөлт, өртөг тооцолтын заавар"-т чухамдаа ноолуурын үйлдвэрийн технологи, бүтээгдэхүүн хувиргалт, мэдээллийн шинэчлэл, ваучер хяналтад нийцсэн сегмент өртгийн бүрдэл, хяналтын цоо шинэ загвар томъёологдож байна. Заавар өнгөрсөн жилүүдийн туршлагыг нэгтгэж, баталгаажуулахын хамт мэдээлэл шинэчлэл, монгол улсын албан татвар, бусад хуулиудын шаардлагад нийцүүлэн үндсэн цех тасаг, дамжлагын үе шатны өртөг тооцолт, дотоод төсөвлөлт, хяналт, мэдээллийн сүлжээг тогтсон нэг хэв загварт оруулж журамлах зорилготой гэдгийг тэмдэглэх нь чухал.

Технологи, бүтээгдэхүүн хувиргалт, зохион байгуулалтын онцлогт нийцүүлэн сегмент өртгийн бүртгэл, хяналтын шинэчилсэн хэв загварыг хэвшүүлэхдээ хамсарсан зардал хуваарилалт, үндсэн ба дайвар үйлдэхүүний өртөг тооцолтыг оролцуулан технологийн үе шатны бүрэн шингээлтээр өртөг хянах хувилбарыг бид сонгож авсан гэж хэлэх үндэслэл бүрэн бий.

Тэмээ, ямаа, хонины ноос, ноолуур оруулж, нэхмэл, сүлжмэл бэлэн бүтээгдэхүүн эцэслэн үйлдвэрлэх технологийн нарийн төвөгтэй, нийлмэл шинжээс үүдэн бараг бүх дамжлага хуваагдлын цэг болж хувирахаас гадна самнасан, бөмбөгөн (топс) ноос ноолуур, ээрмэл, нэхмэл, сүлжмэл хагас боловсруулсан зүйлс, эцсийн үндсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцад олон төрлийн эргэж ашиглагдах дайвар зүйлс, технологи гологдол, тэр ч бүү хэл элдэв үрэгдэл хаягдал (чийг, жингийн алдагдал, хог шороо гэх мэт) их тоогоор үүсч байна.

Ангилан ялгахад түүхий ноос ноолуур орж, технологи хувиргалтын явцад олон төрөл, өнгө, ангилалын үндсэн түүхий эдээс гадна хог, шороо, тостой, богино ноос зэрэг эргүүлж ашиглах ба ашиглахгүй элдэв үрэгдэл хаягдал ч үүснэ.

Энд сегмент үндсэн бүтээгдэхүүн: ангилсан, угаасан, самнасан, багласан (пресс), будсан ноос ноолуур, холио, Топс, Утас, сүлжмэл, оёмол, нэхмэл, зөөлөн оёмол хагас боловсруулсан зүйлс, эцсийн сүлжмэл, оёмол нэхмэл үйлдэхүүн, дайвар бүтээгдэхүүн, технологи хаягдал гэсэн томъёололыг мөрдүүлж хэвшүүлэхээр зааварт тусгав.

Хуваагдлын цэг - технологи үе шатны хамсарсан зардал хуваарилалт, үндсэн, дайвар үйлдэхүүний өртөг тооцолтын бүх шинэчилсэн процедурыг өртгийн хүснэгт, файлуудад дэлгэрэнгүй тусгаж, бүх нийтэд хэвшүүлэхээр тусгаж өгөв. Чухамдаа дамжлагын хамсарсан зардал хуваарилалт хийгээд үндсэн ба дайвар бүтээгдэхүүний өртөг тооцолт өнөөдрийг хүртэл тогтсон нэг загварт ороогүй, түүхий эд, хагас боловсруулсан зүйл, эцсийн үйлдэхүүний тоо, урт (метр), жин, өмнөх дамжлага, цаг үе, стандарт өртөг, шууд хөдөлмөрийн цаг, дүн зэрэг өөр өөр бааз, туйлын олон коэффициент өөрсдийн үзэмжээр сонгон хэрэглэж иржээ.

Эдгээрийг нэг мөр цэгцэлж, бүх дамжлага, цехүүд үндсэн, дайвар үйлдэхүүний тоо, метр, жин болон зах зээлийн хэвийн үнийг хамсарсан зардал хуваарилалтын гол баазаар сонгож хэрэглэхийг заав. Цувималаас ангид дайвар үйлдэхүүнд өртөг тооцдоггүй өнөөгийн практикт шүүмжлэлтэй хандсан зүйл ч бас бий. Эцэст, сегмент өртгийг бүрэн шингээлтээр бүрдүүлэх нь мэдээллийн шинэчлэл, монгол улсын татварын хуулиар тунхагласан түгээмэл нөхцөл төдийгүй дэлхийн тогтсон жишиг, орлого хэмжилт, тайлагналд нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын түгээмэл хэл билээ. Орлого, ашгийн хэмжилт, тайлагналд бүрэн шингээлт, шууд өртөг тооцолт гэж үндсэн 2 суурь байдаг. Эдгээр сууриуд сегмент өртгийн сувгуудыг журамлаж, тэнцэл дэх үлдэгдэл актив ба цаг үеийн ашиг тооцож, эерэг сөрөг цэвэр мөнгөн урсгалуудыг тайлагнах арга хэлбэрийн хувьд ялгагддаг.

Өртгийн хүснэгт, файлууд үндсэн цех, тасаг, дамжлагын өртгийн ваучеруудаар цуглуулсан технологи хувиргалт, үе шатны хамсарсан зардал хуваарилаж, үндсэн, дайвар үйлдэхүүний өртгийг жинлэсэн дундажаар тооцох бүх процедурыг тогтсон нэг хэв загварт журамлаж, алгоритмчилсэн үндсэн баримт бичиг гэвээс зохилтой. Санал оруулж буй зааварт сегмент бүр үндсэн 4 хүснэгт файл дуудаж, өртөг тооцолтыг нэг хэвээр алгоритмчлах учиртай. Үүнд:

Түүхий эдийн жинлэсэн дундаж өртөг. Файл 3 үндсэн үүрэгтэй. **а)** Тооцоо гаргагчийн материалын тайлан, дамжлагын оруулга, шилжилт, үлдэгдлээр (өнгө, төрөл, загвар, фасон, артикулын тоо, метр, жин) түүхий эд, хагас боловсруулсан зүйлсийн хөдөлгөөний уялдаа, биет балансыг шалгаж хянах. **б)** Өртгийн ваучер, түүхий эд, хагас боловсруулсан зүйлсийн хөдөлгөөний тайлангаас нэгж жинлэсэн дундаж өртөг дуудаж, шилжүүлсэн, үлдэгдэл өртгийг

хуваарилах, в) эргүүлж ашиглахгүй технологи хаягдал, өртөг тооцохгүй эргүүлж ашиглах дайвар зүйлсийг үндсэн түүхий эд, хагас боловсруулсан зүйлсийн өртөгт шингээж, дундаж өртгийн залруулга хийх зэрэг болно. Дашрамд, монгол улсын татварын шинэ хуулиар дамжлагын оруулга, шилжилт, үлдэгдлийг жинлэсэн дундаж өртгөөр бүртгэхээр хуульчилсан явдал мэдээллийн шинэчлэл, олон улсын бүртгэлийн стандартад нийцэж, орлого, үр дүн хэмжилт хийгээд тэнцэл дэхь үлдэгдэл нөөцийн үнэлгээг төгс болгох ач тустай зүйл болсон. Дамжлагын өртгийн тайлан. Санхүү, өртөг, удирдлагын бүртгэл, тайлагналд чухал үүрэгтэй, дотоод хяналтын үндсэн тайлан юм. Монгол улсын Сангийн сайдын баталсан журнал маягт зааварт тунхагласан зохиомжийн дагуу үе шатны өртөг тооцолтын уг тайланг цех тасаг, сегментүүд сар бүр бэлтгэхээр зааварт тусгасан.

Нэгж дундаж өртгийн калькуляци (Х-3). Хуваагдлын цэг - технологи дамжлага, үе шат бүрт хувиргасан үндсэн, дайвар зүйлсийн нэгж өртгийг бүрэн шингээлтээр гаргаж авна. Өртгийн ваучер (Ж-5, Ж-6) технологи, хувиргалтын зардлыг нийт дүнгээр цуглуулахаас биш үндсэн, дайвар үйлдэхүүнд хуваарилахгүй. Эндээс хуваагдлын цэг-технологий үе шатны хамсарсан зардлыг үндсэн, дайвар зүйлсийн (үйлдэхүүн) бүх өнгө, төрөл, загваруудад хуваарилах асуудал үүсч байна.

Шилжүүлсэн, үлдэгдэл өртгийн тооцоо (Х-4). Нэгж жинлэсэн дундаж өртгөөр дамжуулж, өртгийн ваучеруудад шилжүүлсэн ба үлдэгдэл өртгийн хуваарилалт хийхэд туслана. Түүхий эдийн жинлэсэн дундаж өртөг (Х-1), Дамжлагын өртгийн тайлан (Х-2), Шилжүүлсэн, үлдэгдэл өртгийн тооцоо (Х-4) файлын зохиомж 3, 4, 5, 6-р хавсралтаас үзнэ үү. Толилуулж буй гурав дахь заавар ("Дуусаагүй үйлдвэрлэлийн нэгтгэл, калькуляци, борлуулалт, удирдлага, үйлдвэрлэлийн бус хүрээ: төсөвлөлт, хяналт, тайлагналын шинэчилсэн загвар") (5 хэсэг, 100 орчим хуудас)-т холбогдогч талууд санал өгч, 2001 онд үйлдвэрлэлд шилжсэн. Бүхэлдээ Говь ХК өртгийн хяналт, дотоод мэдээллийн сүлжээг шинэчлэхэд чиглэсэн.

Дуусаагүй үйлдвэрлэл нэгтгэлд ангилан ялгах: говь, пүүс, угаах: говь, пүүс, хялгас ялгах: говь, пүүс, пресс: говь, пүүс, нэхэх, сүлжих, оёх, загвар, захиалгат, будах, ээрэх, утасны склад, Монкашмер, говь 2-утасны склад, гүйцэтгэх, говь 2-топс, говь 2-ээрэх, говь 2-сүлжих, говь 2-оёх, говь 2-зөөлөн оёдол, ангилсан ноос ноолуурын склад: говь, пүүс зэрэг Говь ХК технологи, хувиргалтын 27 дамжлага, цех тасгийн өртгийн ваучерүүд хамаатай. Ваучеруудын нэгтгэлд нийт зардлыг 29 нэрийн дэлгэрэнгүй зүйл, задгай жагсаалтаар тусгаж, шууд материал, шууд хөдөлмөр, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал гэсэн 3 сувгаар давхар журамлаж товчоолно.

Өртгийн нэгдсэн калькуляци. Сар бүр таваар зориулалтаар үйлдвэрлэсэн самнасан, бөмбөгөн (топс) ноолуур, дан, давхар, деталь утас, сүлжмэл, нэхмэл, оёмол бэлэн үйлдэхүүний өнгө, төрөл, загвар, фасон, артикул тус бүрт нэгж дундаж өртөг тооцож, өртгийн нэгдсэн калькуляци жилийн эхнээс өссөн дүнгээр зохионо.

Энэ ажлын эрэмбэ дараалал, процедур:

- 1) Өртгийн ваучеруудыг нэгтгэж, Говь ХК, говь ба пүүсээр цуглуулсан нийт өртгөөс дотоод эргэлт хасаж, самнасан ноолуур, топс, ээрмэл, сүлжмэл, нэхмэл, оёмол эцсийн үйлдэхүүнд ногдуулан хуваарилах хамсарсан зардлыг цэвэр дүнгээр (дотоод эргэлтгүй) жилийн эхнээс өссөн дүнгээр цуглуулах (Дуусаагүй үйлдвэрлэлийн нэгтгэл).
- 2) Дуусаагүй үйлдвэрлэл, ваучеруудын нэгтгэл зөв хийгдсэн, бас бараа (түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн үйлдэхүүн) материалын үлдэгдэл өртөг үлдэгдлийн тэнцэлд зөв сууж, орлого үр дүнгийн тайланд шилжүүлсэн борлуулсан бүтээгдэхүүний өртөг үндсэн дансдын бичилтээр зөв илэрхийлэгдсэн гэдгийг итгэл үнэмшилтэй нотлохын тулд үйлдвэрлэсэн ба борлуулсан бүтээгдэхүүний өртгийн тайланг сар бүр өссөн дүнгээр бэлтгэж, дансдын зохих балансжилт, уялдааг хангах.

- 3) Өртгийн файл: Х-1 нэгтгэлээс өртгийн нэгдсэн калькуляцид холбогдох эцсийн (гадагш борлуулах самнасан ноолуур ба топс, утас: дан, давхар, деталь, нэхмэл, сүлжмэл, оёмол үйлдэхүүн дэлгэрэнгүй өнгө, төрөл загвараар) бүтээгдэхүүнд шилжүүлсэн үндсэн түүхий эд, материал, хагас боловсруулсан зүйлсийн дэлгэрэнгүй төрөл ангилалын дагуу биет (тоо, метр, жин) болон өртгийн балансжилт үйлдэж, нягт уялдуулах.
- 4) Тэдгээрийг анхдагч түүхий эд - түүхий ноос ноолуурт шилжүүлж хөрвүүлэхдээ жилийн эхнээс өссөн дүнгээр хуримтлуулсан технологи, хувиргалтын үндсэн дамжлагуудын түүхий эд, хагас боловсруулсан зүйлс, эцсийн бүтээгдэхүүний гарцын тайлан ба зохих параметруудыг ашиглах.
- 5) Өртгийн файл: Х-2 нэгтгэлээс өртгийн нэгдсэн калькуляцид холбогдох эцсийн (Таваарын самнасан ноос ноолуур, топс, утас, нэхмэл, сүлжмэл, оёмол үйлдэхүүн дэлгэрэнгүй өнгө, төрөл загвараар) бүтээгдэхүүний хөдөлгөөний биет (тоо, метр, жин), өртгийн балансжилт гаргаж, нягт уялдуулах.
- 6) Дуусаагүй үйлдвэрлэл нэгтгэлээс "шууд материал" сувгаар журамлаж үзүүлсэн үндсэн түүхий эдийн цэвэр дүнг "дотоод эргэлтгүй" гарцын параметрээр бодож хөрвүүлсэн анхдагч түүхий эд - түүхий ноос ноолуурын биет масст хувааж, өртгийн нэгдсэн калькуляцид нэгж дундаж өртөг гаргах
- 7) "Шууд хөдөлмөр", "Нэмэгдэл зардал" сувгуудын хувьд дуусаагүй үйлдвэрлэлийн нэгтгэлд холбогдох мөнгөн урсгал буюу хамсарсан зардлыг эдийн засагчдаас урьдчилан товлосон стандарт өртгийн калькуляцид суурилуулан эцсийн бүтээгдэхүүний үндсэн төрөл, анги, загваруудад хуваарилах хэрэгтэй.

Борлуулалт, удирдлага, үйлдвэрлэлийн бус хүрээ: төсөвлөлт, хяналт, тайлагнал

Төслийн хүрээнд санхүү мэдээллийн сүлжээнд нийцүүлэн удирдлагын хяналт, борлуулалт, удирдлагын зардлын төсөвлөлт, тайлагналын өнөөгийн загварыг эргэн хянаж, шинэчилсэн загвар, дансны жагсаалтыг томъёолсон. Борлуулалтын зардлын төсөвлөлт, бүртгэл, хяналт, тайлагналд борлуулалт тээвэр даатгал, борлуулалт үйл ажиллагааны зардал гэсэн 2 сувгийг хэрэглэнэ. Борлуулалтын тээвэр даатгалын зардал дансны сувгаар гадаад дотоод борлуулалтын тээврийн хөлс, замд яваа барааны даатгал хураамж, түр хадгалах ба бусад зардлуудыг холбогдох гэрээний нөхцлөөр төсөвлөн суутгаж, зохих баримт бүрдлийн дагуу гүйцэтгэл хянана.

Харин борлуулалтын үйл ажиллагааны зардал дансны сувгаар гадаад дотоод борлуулалтын ачиж буулгах зардал, дэлгүүр, үзэсгэлэн худалдаа, худалдагчдын цалин хөлс, нийгмийн даатгал, шуудан холбоо, гааль баталгаажуулалт, бичиг хэрэг, гүний гааль, мал эмнэлэг, шинжилгээний хураамж, худалдаа үйлдвэрийн танхмийн лиценз, төлбөр: форма-а, дэлгүүрийн түрээс, гэрээт борлуулагчийн шимтгэл зэрэг борлуулалтын үйл ажиллагааны бүх зардлыг төсөвлөж, гүйцэтгэлд хяналт тавина.

Ерөнхий удирдлагын зардлын төсөвлөлтөд гүйцэтгэх удирдлага, тамгын газар, маркетинг худалдааны алба, санхүү эдийн засаг, түүхий эдийн алба, Говь-2 үйлдвэрийн захиргаа, үйлчилгээ аж ахуй, Хасар клуб гэсэн захиргааны үндсэн 10 хэлтэс тасаг, нэгжид хамаарах бүх орон тоо, цалин, нийгмийн даатгал, материаллаг үйлчилгээний зардлыг хамааруулна.

Харин гуанз, сувилал, амралт, зоорь, орон сууц, цэцэрлэг, нөхөн засвар цех зардлыг ерөнхий удирдлагын зардлын төсөвлөлтөөс тусгаарлаж, тэдгээрийн орлого, өртөг, үр дүнг бусад үйл ажиллагааны үр дүнгээр төсөвлөж тайлагнах нь зүйтэй. Бас удирдлагын үйл ажиллагааны төсөвлөлт, гүйцэтгэл хяналт, тайлагналаас шагнал урамшуулал дансны сувгийг хасах хэрэгтэй. Учир нь татварын хуулиар шагнал урамшил өртгийн бүрдэл хэсэг биш, ашгаас нөхөгдөх ёстой.

